

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
2017 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/49/СТА-ТШЗ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524
Цахимхаяг:

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитынгазар
Байршил: Аймгийн ЗДТГ-
ын байр, 1-р давхар
Цахим хуудас:
www.audit.mn
2018 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 19-нээс 2 дугаар сарын 04-ны хооронд хийхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газарт 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 02/134 тоот албан бичгээр ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 31-нээс 2 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 05-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн хүргүүлэнэ.

2.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Монгол улсын Төсвийн тухай тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

3.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 1-р зүйлд “шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Бусад төсвийн байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны төсвийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас аймгийн төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын

эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 5 чиглэлээр 20 эрсдэлтэй асуудалд 20 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ШШЕГазрын санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газраас боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үндэслэн 2015 оноос бодлогын баримт бичиг боловсруулан санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэдэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Unicus” програм хангамж ашиглажээ.

5.Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

6.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тус газар нь газрын дарга, захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс, харуул хамгаалалтын тасаг, шийдвэр гүйцэтгэлийн тасаг гэсэн бүтэцтэй бөгөөд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 30, үйлчилэх ажилтан 1 нийт 32 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны үйл ажиллагаанд 460,7 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант онд улсын төсвөөс 450,7 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,0 сая төгрөгийн орлого оруулан бүгд 460,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажилласан байна. Гүйцэтгэлээр 458,3 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулан төсвөө 2,4 сая төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг төв төрийн санд төвлөрүүлжээ.

Зардлын зүйл ангиар авч үзвэл цалинд 329,2 сая төгрөг, НДШ-д 11,3 сая төгрөг, тогтмол зардалд 32,0 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 20,1 сая төгрөг, норматив зардалд 16,3 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 27,5 сая төгрөг, томилолт зочны зардалд 3,2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5,4 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 10,8 сая төгрөг төгрөг тус тус зарцуулжээ.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар ШШШГЕГ-аас 0,2 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал зардалд зарцуулсан байна.

7.Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдоогүй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны батлагдсан төсвийг shilendans.gov.mn вэб сайтад байршуулсан байна.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаж, төсвийн талаарх мэдээллийг байгууллагын самбар болон вэб сайтад байршуулжээ.

Тус аудитын газраас 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллага шилэн дансны тухай хуулийн 6.1.2,

6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.4.5 -т заасан заалтуудыг зөрчиж 450,2 сая төгрөгийг тусгаж харуулаагүй байсныг илрүүлэн зөрчлийг арилгуулах 2017.12.20 21/79 албан шаардлага өгч биелэлтийг 2017.12.20 №01/2215 тоот албан тоотоор авч хангуулсан.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-SHSHGA файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

8.Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Санхүүгийн тайлангийн аудитаар 30,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч залруулга хийгдлээ.

9.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого, санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, НДШимтгэл, ХХОАТ, түлш халаалт, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

10.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой материаллаг дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 0,6 сая төгрөгөөр, зарлагыг 18,4 сая, Үр дүнгийн тайлангийн зардлыг 5,7 сая төгрөгөөр, Өмчийн өөрчлөлтийн тайланг 2,8 сая төгрөгөөр, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2,9 сая төгрөгөөр, өглөг 0,4 сая төгрөгөөр нийтдээ 30,8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнажээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг НББОУлсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон бусад тайлан мэдээг үнэн зөв гаргах", 26.1-д "Төсвийн байгууллага нь НББОУлсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрэл суурьтай НББ хөтлөнө", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар

батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: *Дээрхи алдаа зөрчлүүдийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад залруулга хийсэн.*

Аудитаар материаллаг бус дараах алдаа, зөрчил илрэв. Үүнд:

- ШШГГазрын бэлтгэж ирүүлсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулга нь холбогдох зааварын дагуу бэлтгэгдээгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулгыг Сангийн сайдын 2016 оны 388 дугаар тушаалын хавсралтад заасан зааварын дагуу бэлтгэж ирүүлж байх талаар зөвлөмж өгөв.

11.Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил байхгүй.

12.Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Байхгүй.

13.Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах дансдын тооцооллыг гүйцэд мөшгин шалгах боломжгүй байсан. Үүнд:

1.Хоол, түлш, халаалт, шатахууны зардлуудын зарцуулалтыг гүйцэд шалгах боломжгүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар үзэх шаардлагатай.

14.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 30,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч залруулга хийв.

15.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн ба зөвлөмж өгөгдөөгүй байна

17.Зөрчилгүй санал дүгнэлт

Аудитаар илэрсэн залруулга хийгдсэн алдаа, зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөллийг эс тооцвол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл,

ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, менежментийн захидал ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо: 2017.02.05

Х.ЖЕНИСБЕК
Огноо: 2017.02.05

Х.МАНАРГҮЛ
Огноо: 2017.02.05